

Хотын хөдөө аж ахуйн төв байгууллага

1924 оны 11 дүгээр сард улсын анхдугаар их хурлын 8, 13 дугаар тогтоолоор аж ахуйн асуудлыг сангийн яамнаас тусгаарлаж, аж ахуйн яам байгуулсан.

1930-7-25-нд орчим Аж ахуйн яамыг татан буулгаж хоёр яам болгоход мал, тариалангийн яам байгуулагджээ.

1958-1-11-нд Сайд нарын Зөвлөлийн 6 дугаар тогтоолоор Улаанбаатар хотын дэвсгэр нутаг Амгаланд “Амгалан” нэртэй сүү, ногооны чиглэлийн сангийн аж ахуйг 1968 онд байгуулж Амгалан дахь ногооны комбинатын бааз дээр төвлөрүүлэхээр тогтоожээ.

1961-4-19-нд Сайд нарын Зөвлөлийн 181 дүгээр тогтоолоор Амгалангийн сангийн аж ахуйн саалийн фермийг өргөтгөн, сүүний чиглэлийн Гацууртын сангийн аж ахуйг байгуулахаар тогтоожээ.

1972-11-3-нд Сайд нарын Зөвлөлийн захирамжаар томилогдсон комисс БНБАУ-ын тусламжаар Улаанбаатар хотын Толгойтын районд баригдсан хүнсний ногооны шилэн дарлагын барилга байгууламжийг хүлээн авчээ.

1974-10-3-нд Сайд нарын Зөвлөлийн 269 дүгээр захирамжаар ЗХУ-ын техникийн тусламжтайгаар Гацууртын сангийн аж ахуйн Аюушийн аманд барьсан 800 үнээний фермийн иж бүрэн барилгыг ашиглалтад хүлээн авчээ.

1924- онд / одоогийн хөдөө аж ахуйн яамны системд шилжүүлжээ. /Улаанбаатар хотын Сонгины биокомбинат 1929-9-23-нд үхрийн мялзан эсэргүүцэх станцын суурь дээр үндэслэн 1971-онд Улаанбаатар хотод Унгарын техник эдийн засгийн тусламжаар Сонгины био үйлдвэрийн үндсэн үйлдвэрлэлийн зарим хэсэг ашиглалтад оржээ.

1972-10-12-нд Сайд нарын Зөвлөлийн 283 дугаар захирамжаар ЗХУ-ын хөрөнгөөр Улаанбаатар хотод баригдсан мал эмнэлэг, бактери шинжилгээний төв лабораторийн иж бүрэн барилга байгууламжийг ашиглалтад хүлээнбайгуулагджээ.

1960-7-19-нд Сайд нарын Зөвлөл, Намын Төв Хорооны 318, 223 дугаар тогтоолоор усны аж ахуйн барилгын газрыг Улаанбаатар хотод байнгын салбар контор бүхий усны аж ахуйн барилга-монтажийн газар болгон өөрчилж, мөн усны аж ахуйн зураг төсөл хайгуул шинжилгээний конторыг байгуулахаар тус тус тогтоожээ

1967-5-5-нд Сайд нарын Зөвлөлийн 129 дүгээр тогтоолоор Улаанбаатар хотын хайгуул отряд, хэсгийг барилга, угсралтын конторыг түшиглүүлэн төвлөрүүлжээ

1971-12-17-нд Сайд нарын Зөвлөлийн 408 дугаар тогтоолоор Улаанбаатар хотын гүйцэтгэх захиргаанд усны аж ахуйн хэлтсийг засварын групптэйгээр байгуулахаар тогтоожээ

1933, 1941, 1963, 1963, 1966, 1971, 1973 онуудад Улаанбаатар хотын орчимд усны үер болж түүнтэй тэмцэх хохиролыг арилгах сэргээн босгох арга хэмжээнүүдийг авч байжээ.